

Сумын 2021 оны үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүн

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	80.1	0.2	
	2.Үндэсний хөтөлбөр болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	83.9		
	3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	91.6		
Дундаж		85.2	17	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт	76.8	0.6	
	2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	71.4		
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт	85.7		
	4.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	90.6		
	5.Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт	82.9		
Дундаж		81.4	48.8	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан	76.4	0.2	
	2.Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт	87.1		
Дундаж		82.3	16.5	
Ерөнхий үнэлгээ				82.2

Сумын үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлт тус бүрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд дараах асуудлыг цаашид анхаарч ажиллахыг зөвлөж байна.

1.Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, хэрэгжилт үр дүнг ахиулах.

2.Төрийн албаны тухай хуулийн 55.3 заалт, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу байгууллага бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тусгайлан боловсруулан баталж хэрэгжилт үр дүнг тооцож байх.

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг журмын дагуу хугацаанд нь үнэлж дүгнэн баталгаажуулж байх.

4. Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг тооцож байх.

5. Хугацаатай бичиг баримтын бүртгэлийг сайжруулах.

6. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийг баримтжуулах.

7. Мэдээллийн ил тод байдлыг хангаж байгууллагын болон хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг сайжруулах.

8.Шилэн дансанд мэдээллийг чанартай бүрэн байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

9.Хулд сумын ЭМТөвөөс бүртгэлээс хасуулж байгаа хөрөнгийг Аймгийн ИТХ-аар батлагдсан журмын дагуу бүртгэж шилжүүлэн авах.

- 10.Шинээр гарсан дүрэм журмыг судлах ажлыг төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөө болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилт үр дүнг тооцож байх.
- 11.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хэрэгжээгүй ажлыг 2022 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.
- 12.Захирамжлалын баримт бичигт хяналтын дагалдах хуудас хэрэглэх
- 13.Эрх зүйн хөтөч нарын ажлыг нэгтгэн дүгнэж тайлagnаж байх
- 14.Монгол Улсын баримт бичгийн стандарт болон Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах. Баримт бичгийн бүрдэл дутуу үүнд анхаарч ажиллах.
- 15.Хэвлэмэл хуудасны индексийг нэр төрлөөр нь шинэчлэн батлуулах (Байгууллагууд бас орно).
- 16.Захирамж, тушаалын бүртгэлийг хөтлөх
17. Монгол бичгийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж, сургалтын эцсийн шалгалтыг өгч батламж авхуулсан байх

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС